



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/2226.

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Арга аргачлал батлах тухай” 100 дугаар тушаал, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/189 дүгээр тушаалын хавсралт Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан хаагчдын жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх “Ажлын хэсэг”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Захиргаа, удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга

Эм хангамжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Чанарын хяналтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга

Эм үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

Эм шинжлэх лабораторийн дарга

Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газрын ахлах мэргэжилтэн


Нарийн бичгийн дарга:

Агентлаг, хяналтын лабораторийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Дотоод аудит, үнэлгээний асуудал хариуцсан
мэргэжилтэн

2. Албан хаагчдын жилийн эцсийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг
үнэлсэн үнэлгээг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагчид
даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА